ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын ерөнхий боловсролын Минжит булган цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХОА-2025/012/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: Н.Батжаргал<br>Утас:70432545 Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .... 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .... 8
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** .... **Error! Bookmark not defined.**
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.... **Error! Bookmark not defined.**
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .... **Error! Bookmark not defined.**
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.... **Error! Bookmark not defined.**
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд **Error! Bookmark not defined.**
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .... **Error! Bookmark not defined.**
3.5.1 Төсвийн төлөвлөлт.... **Error! Bookmark not defined.**
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .... **Error! Bookmark not defined.**
3.5.3 Нэмэлт төсөв .... **Error! Bookmark not defined.**
**4. АУДИТЫН ТАЙЛАН** .... **Error! Bookmark not defined.**
4.1 Ерөнхий зүйл .... **Error! Bookmark not defined.**
4.2 Материаллаг байдал.... **Error! Bookmark not defined.**
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .... **Error! Bookmark not defined.**
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал **Error! Bookmark not defined.**
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .... **Error! Bookmark not defined.**
4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .... **Error! Bookmark not defined.**
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .... **Error! Bookmark not defined.**
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .... 9
5.1 ЗӨВЛӨМЖ .... 10
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .... 26

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.03.12 № 2/102

танай ____________-ны №____________-т

БУЛГАН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 2-Р
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ц.СОНГУУЛЬ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын Минжит булган цогцолбор сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй болович өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- *Багш, ажилчдад оны эцэст мөнгөн урамшуул олгож, шагнасан 55,765.5 мянган төгрөг,*
- *Сүү хөтөлбөрийн зарцуулалт нь хүүхэд өдрөөр тооцсон дүнгээс илүү зарцуулсан 3,825.6 мянган төгрөг,*
- *Сүү хөтөлбөрийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй 1,512.0 мянган төгрөг,*
- *Худалдан авах ажиллагааны төлөвлөөгүй, хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр шууд худалдан худалдан авалт хийсэн 96,551.2 мянган төгрөг,*
- *барилгын урсгал засварын материалын тайлан гаргаагүй, зарцуулалтыг нотлох анхан шатны баримтгүй 4,431.3 мянган төгрөг,*

- *Дулаан халаалтын нэгдсэн системд холбогдсоноор нүүрсний үлдэгдэл ашиглагдахгүй он дамжиж байгаа 6,328.5 мянган төгрөг,*
- Ажилчдын цалин хөлснөөс суутгасан хувь хүний орлогын албан татварын өглөгийг илүү шилжүүлсэн *авлага нэмэгдүүлсэн* 26,577.6 мянган төгрөгийн *зөрчлүүд тус тус байна*

**Асуудлыг онцолсон хэсэг**

Юнивишн ХХК-аас урт хугацаат зээлийн гэрээгээр 58,788.0 мянган төгрөгийн интернэтийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Булган сумын ерөнхий боловсролын Минжит булган цогцолбор сургууль 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилтын хүрээнд 92 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Боловсролын газрын даргаар дүгнүүлэн 89.2 хувьтай үнэлэгдсэн байна.байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **323,768,062.22** | **413,959,008.04** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 232,686,280.92 | 294,600,810.21 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 232,686,280.92 | 294,600,810.21 |
| **3121** | **Төгрөг** | 232,686,280.92 | 294,600,810.21 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 232,686,280.92 | 294,600,810.21 |
| **33** | **АВЛАГА** | 6,974,357.02 | 26,776,670.40 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,077,657.02 | 199,013.20 |
| **335** | **Бусад авлага** | 3,896,700.00 | 26,577,657.20 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 26,577,657.20 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 00.00 | 7,280,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 00.00 | 7,280,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 84,107,424.28 | 85,301,527.43 |
| **351** | **Түүхий эд материал** | 8,021,984.00 | 17,713,940.15 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,174,534.00 | 16,188,800.15 |
| 35130 | Эм боох материал | 1,847,450.00 | 1,525,140.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 76,085,440.28 | 67,587,587.28 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 20,853,480.00 | 18,524,802.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 27,146,600.00 | 15,521,877.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 7,492,928.78 | 6,321,778.78 |
| 35460 | Хүнсний материал | 20,592,431.50 | 27,219,129.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,846,689,792.76** | **1,815,844,194.94** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,846,689,792.76 | 1,815,844,194.94 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,742,022,392.76 | 1,711,176,794.94 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,854,167,461.00 | 1,854,167,461.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -603,207,958.36 | -719,296,650.28 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 600,772,634.58 | 746,860,976.58 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -340,710,352.76 | -371,026,641.78 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 371,394,786.19 | 441,591,611.19 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -194,293,268.29 | -295,019,052.17 |
| 39217 | Ном | 53,899,090.40 | 53,899,090.40 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 104,667,400.00 | 104,667,400.00 |
| 39301 | Програм хангамж | 330,000.00 | 330,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 104,612,400.00 | 104,612,400.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -275,000.00 | -275,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,170,457,854.98** | **2,229,803,202.98** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **13,776,826.14** | **36,407,528.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 13,776,826.14 | 36,407,528.00 |
| **413** | **Өглөг** | 13,776,826.14 | 36,407,528.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 13,776,826.14 | 4,968,028.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 31,439,500.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 31,439,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,156,681,028.84** | **2,193,395,674.98** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,156,681,028.84 | 2,193,395,674.98 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,937,494,876.00 | 1,937,494,876.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,937,494,876.00 | 1,937,494,876.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -987,148,821.85 | -950,434,175.71 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -987,148,821.85 | -987,148,821.85 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 36,714,646.14 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,206,334,974.69 | 1,206,334,974.69 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,170,457,854.98** | **2,229,803,202.98** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,799,525,262.00** | **4,092,312,636.15** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **149,987,100.00** | **145,586,436.15** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 149,987,100.00 | 145,586,436.15 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 149,987,100.00 | 145,586,436.15 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 4,224,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,562,700.00 | 39,079,200.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 139,424,400.00 | 102,282,536.15 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,649,538,162.00** | **477,182,700.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 3,469,543,500.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 00.00 | 477,182,700.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 477,182,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,639,811,955.63** | **4,055,597,990.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,639,811,955.63** | **4,055,597,990.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,576,636,341.63 | 3,901,149,988.44 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,793,935,337.51 | 2,617,824,214.75 |
| 210101 | Үндсэн цалин | 1,228,340,682.15 | 1,586,167,266.56 |
| 210102 | Нэмэгдэл | 544,270,630.72 | 868,980,058.19 |
| 210104 | Урамшуулал | 21,324,024.64 | 162,676,890.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 227,508,611.71 | 326,787,613.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 152,374,050.48 | 222,488,941.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,926,358.95 | 26,175,169.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,542,157.51 | 13,677,290.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,397,184.98 | 12,889,242.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 35,268,859.79 | 51,556,969.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 125,737,300.00 | 443,749,768.43 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,486,516.57 | 19,409,162.96 |
| 210302 | Түлш, халаалт | 111,250,783.43 | 412,685,533.47 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 11,655,072.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 131,591,922.00 | 88,021,497.00 |
| 210502 | Хоол, хүнс | 129,522,822.00 | 88,021,497.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 30,000,000.00 | 4,431,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 30,000,000.00 | 4,431,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,377,500.00 | 69,178,129.21 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,046,500.00 | 37,729,425.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 15,331,000.00 | 31,448,704.21 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 245,932,277.41 | 351,157,465.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,172,440.00 | 73,436,703.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,161,448.00 | 30,589,998.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 183,598,389.41 | 247,130,764.82 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 63,175,614.00 | 154,448,001.57 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 63,175,614.00 | 124,315,070.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 62,552,600.00 | 124,315,070.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 30,132,931.57 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 30,132,931.57 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **159,713,306.37** | **36,714,646.14** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **150,536,230.55** | **36,714,646.14** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,937,494,876 | 1,206,334,975 | -850,211,273 | 2,293,618,578 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,937,494,876** | **1,206,334,975** | **-850,211,273** | 2,293,618,578 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00 | 00 | -153,459,014 | -153,459,014 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,937,494,876** | **1,206,334,975** | **-987,148,822** | 2,156,681,029 |
| D01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,937,494,876** | **1,206,334,975** | **-987,148,822** | 2,156,681,029 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,937,494,876** | **1,206,334,975** | **-987,148,822** | 2,156,681,029 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00 | 00 | 36,714,646 | 36,714,646 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,937,494,876** | **1,206,334,975** | **-950,434,176** | 2,193,395,675 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,660,100,862.00** | **3,992,264,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,562,700.00** | **45,538,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,562,700.00 | 45,538,600.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 10,562,700.00 | 43,303,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 4,224,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,562,700.00 | 39,079,200.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 2,234,700.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,649,538,162.00** | **3,946,726,200.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 3,469,543,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 128,537,300.00 | 477,182,700.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 00.00 | 477,182,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,504,620,642.10** | **3,930,350,270.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,504,620,642.10** | **3,930,350,270.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,378,252,778.10** | **3,785,773,399.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,772,351,380.10 | 2,619,723,139.50 |
| 210101 | Үндсэн цалин | 1,111,788,834.41 | 1,517,940,535.67 |
| 210102 | Нэмэгдэл | 618,565,278.59 | 950,648,055.73 |
| 210104 | Урамшуулал | 41,997,267.10 | 151,134,548.10 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 238,127,200.00 | 357,396,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 161,926,600.00 | 246,658,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,050,200.00 | 27,684,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,239,900.00 | 13,842,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,810,000.00 | 13,842,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 38,100,500.00 | 55,369,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 125,737,300.00 | 443,749,768.43 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,486,516.57 | 19,409,162.96 |
| 210302 | Түлш, халаалт | 111,250,783.43 | 412,685,533.47 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 11,655,072.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 77,867,250.00 | 101,239,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 77,867,250.00 | 101,239,050.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,800,000.00 | 3,300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,800,000.00 | 3,300,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,147,500.00 | 85,683,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,046,500.00 | 38,484,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,101,000.00 | 47,199,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 144,222,148.00 | 174,681,041.21 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 121,890,648.00 | 149,005,241.21 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,331,500.00 | 25,675,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **126,367,864.00** | **144,576,871.57** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 126,367,864.00 | 114,443,940.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 125,478,650.00 | 114,443,940.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 30,132,931.57 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 30,132,931.57 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **155,480,219.90** | **61,914,529.29** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 155,480,219.90 | 61,914,529.29 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 77,206,061.02 | 232,686,280.92 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 232,686,280.92 | 294,600,810.21 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,208,687,200 | 3,897,982,639 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 4,208,687,200 | 3,897,982,639 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,067,996,000 | 3,783,538,699 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,839,734,900 | 2,619,723,140 |
| 210101 | Үндсэн цалин | 1,836,747,500 | 1,517,940,536 |
| 210102 | Нэмэгдэл | 978,815,700 | 950,648,056 |
| 210104 | Урамшуулал | 24,171,700 | 151,134,548 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 354,967,000 | 357,396,500 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 241,377,500 | 246,658,400 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 28,397,400 | 27,684,500 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,198,700 | 13,842,300 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,198,700 | 13,842,300 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 56,794,700 | 55,369,000 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 473,872,700 | 443,749,768 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,496,000 | 19,409,163 |
| 210302 | Түлш, халаалт | 416,165,500 | 412,685,533 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 42,211,200 | 11,655,072 |
| **2105** | **Нормативт зардал** | 118,744,500 | 101,239,050 |
| 210502 | Хоол, хүнс | 118,744,500 | 101,239,050 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,300,000 | 3,300,000 |
| 210604 | Урсгал засвар | 3,300,000 | 3,300,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 99,077,900 | 85,683,900 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 36,943,900 | 38,484,300 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 62,134,000 | 47,199,600 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 178,299,000 | 172,446,341 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 152,623,200 | 146,770,541 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,675,800 | 25,675,800 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 140,691,200 | 114,443,940 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 140,691,200 | 114,443,940 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 140,691,200 | 114,443,940 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,208,697,200 | 3,959,897,168 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,469,543,500 | 3,469,543,500 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 3,469,543,500 | 3,469,543,500 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 477,182,700 | 447,049,768 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 43,303,900 | 43,303,900 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,224,700 | 4,224,700 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 39,079,200 | 39,079,200 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 218,667,100.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 232,686,281 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 294,600,810 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 281,304.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 86,313.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг[1] залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Боловсролын газар болон ОНХС-аас үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд дутуу тусгасан 20,245.1 мянган төгрөгийг бүртгүүлэв.
- Юнивишн ХХК-аас урт хугацаат зээлийн гэрээгээр худалдан авсан интернэтийн төхөөрөмж 58,788.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгүүлэв.
- 2025 онд хэрэгжиж дуусах ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан гэрээг дүгнээгүй байхад зардалд бүртгэсэн 7,280.0 мянган төгрөгийг урьдчилгаа дансанд залруулан бүртгэлээ.

Залруулагдаагүй 194,991.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их, хуулийн хугацаанд санхүүгийн тайланг ирүүлээгүй байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчилд[2] 55,765.5 мянган төгрөгийн албан шаардлага өгч, 5,337.6 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 133,888.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

### 3.1. ТӨЛБӨРИЙН АКТ

### 3.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тайлант онд аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн сүү хөтөлбөрийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 1,512.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төлбөрийн акт тогтоох

### 3.2.1 Сүү хөтөлбөрийн зарцуулалттай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Хоолны хүнсний материалын дансны орлого, зарлага, үлдэгдэл нярав болон нягтлан бодох бүртгэлийн үлдэгдэл зөрүүтэй, сүү хөтөлбөрийн зарцуулалт нь хүүхэд өдрөөр тооцсон дүнгээс илүү зарцуулсан 3,825.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3."төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох*.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.2 АЛБАН ШААРДЛАГА

*Илрүүлэлт:* Хамтын гэрээ, дотоод журамд заасны дагуу бүх багш, ажилчдад оны эцэст мөнгөн урамшуул олгож, шагнасан 55,765.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна

*Шийдвэрлэсэн нь*: албан шаардлага өгөх

### 3.3 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.3.1 Худалдан авалттай холбоотой асуудал

***Илрүүлэлт:*** Худалдан авах ажиллагааны төлөвлөөгүй, хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр шууд худалдан худалдан авалт хийсэн 96,551.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Худалдан авах ажиллагааны хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллах

#### 3.3.2 Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

***Илрүүлэлт:*** Нярвын тайлан, анхан шатны баримт бүрдүүлэлт заавар журамд нийцээгүй, барилгын урсгал засварын материалын тайлан гаргаагүй, зарцуулалтыг нотлох анхан шатны баримтгүй 4,431.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3."төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Нярвын тайланг санхүүгийн программаар гаргах, анхан шатны баримт маягтыг үнэн зөв хөтөлж хэвших.

#### 3.3.3 Бараа материалтай холбоотой асуудал

***Илрүүлэлт:*** Дулаан халаалтын нэгдсэн системд холбогдсоноор нүүрсний үлдэгдэл ашиглагдахгүй он дамжиж байгаа 6,328.5 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгаа зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Нүүрсний үлдэгдлийг зохистой удирдаж, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

### 3.3.4 Авлагатай холбоотой асуудал

***Илрүүлэлт:*** Ажилчдын  цалин хөлснөөс суутгасан хувь хүний орлогын албан татварын өглөгийг илүү шилжүүлсэн 26,577.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн  20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Харилцагч талуудтай тооцоог тухай бүр хийж авлага, өглөг үүсгэхгүй ажиллах .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Минжит булган цогцолбор сургууль | Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд дутуу тусгасан | 1 | 20,245.1 | 1 | 20,245.1 | | | 1 | 20,245.1 | | | | |
| | Юнивишн ХХК-аас урт хугацаат зээлийн гэрээгээр худалдан авсан хөрөнгө бүртгээгүй | 1 | 58,700.0 | 1 | 58,700.0 | | | 1 | 58,700.0 | | | | |
| | Урьдчилж гарсан зардал бүртгээгүй | 1 | 7,280.0 | 1 | 7,280.0 | | | 1 | 7,280.0 | | | | |
| **Нийт дүн** | | **3** | **86,313.1** | **3** | **86,313.1** | | | **3** | **86,313.1** | | | | |

*4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* *\/мянган төгрөгөөр/*

| **Аудитад хамрагдсан байгууллагын нэр** | **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс:** | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн** | |
| | | | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Минжит булган цогцолбор сургууль | Бүх багш, ажилчдад мөнгөн урамшуул олгосон | 1 | 55,765.5 | | | 1 | 55,765.5 | | | | |
| | Сүү хөтөлбөрийн зарцуулалт хүүхэд өдрөөр тооцсон дүнгээс илүү зарцуулсан | 1 | 3,825.6 | 1 | 3,825.6 | | | | | | |
| | Сүү хөтөлбөрийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй | 1 | 1,512.0 | 1 | 1,512.0 | | | | | | |
| | Барилгын урсгал засварын материалын тайлан гаргаагүй, зарцуулалтыг нотлох анхан шатны баримтгүй | 1 | 4,431.3 | | | | | 1 | 4,431.3 | | |
| | Дулаан халаалтын нэгдсэн системд холбогдсоноор нүүрсний үлдэгдэл ашиглагдахгүй он дамжиж байна | 1 | 6,328.5 | | | | | 1 | 6,328.5 | | |
| | ХХОАТ-ын өглөгийг илүү шилжүүлснээс авлага нэмэгдсэн | 1 | 26,577.6 | | | | | 1 | 26,577.6 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт дүн** | **6** | **98,440.5** | **2** | **5,337.6** | **1** | 55,765.5 | **3** | **37,377.4** | | |

4.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал *(мянган төгрөгөөр)*

| **Аудитад хамрагдсан байгууллагын нэр** | **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс:** | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | |
| | | | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Минжит булган цогцолбор сургууль | Худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр шууд худалдан худалдан авалт хийсэн | 1 | 96,551.2 | | | | | 1 | 96,551.2 |
| **Нийт дүн** | | **1** | 96,551.2 | | | | | **1** | 96,551.2 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР : Х.БОЛДБААТАР 2025.03.12

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН 2025.03.12

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: Н.БАТЖАРГАЛ 2025.03.12